| 210402 | Тээвэр, шатахуун | 1,900,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,204,500.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,887,000.00 | 2,138,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,887,000.00 | 2,138,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,878,500.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,790,500.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 88,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52,015,309.00 | 22,912,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100,000.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 51,915,309.00 | 22,912,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 5,300,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 5,300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 5,300,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **600,400.00** | **-** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 600,400.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 69,071,542.00 | 30,350,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 69,071,542.00 | 30,350,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 69,071,542.00 | 30,350,500.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Мэргэжлийн боловсролын сургууль нь мэргэжлийн болон техникийн боловсрол олгох чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага.Тайлант онд “Чадвартай багш, чанартай сургалт, чадамжтай төгсөгч бэлтгэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлан оноос эхэлж санхүүгийн үр дүнд суурилуулсан гүйцэтгэлээр санхүүжүүлж эхэлсэн

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Мэргэжлийн боловсролын сургууль нь Монгол Улсын үндсэн хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд  дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/218 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.7 сая төгрөгөөр буюу 3.53 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | 0.00 |
| Авлага | | | 0.00 |
| Бараа материал | 403,011.60 | 549,524.50 | 146,512.90 |
| Үндсэн хөрөнгө | 2,309,736.00 | 2,258,982.40 | -50,753.60 |
| **Нийт хөрөнгө** | **2,712,747.60** | **2,808,506.90** | **95,759.30** |
| Өр төлбөр | 0 | 80,098.70 | 80,098.70 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,712,747.60 | 2,728,408.20 | 15,660.60 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,712,747.60** | **2,808,506.90** | **95,759.30** |

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 549.5 сая төгрөг болж 146.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 358.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 6.1 сая төгрөгийн аж ахуйн материалыг Боловсрол шинжлэх ухааны яамнаас үнэгүй хүлээн авч, тус сургуулийн багш нарын бүтээлийн 16.8 сая төгрөгийн бараа материалыг орлогод бүртгэж, үйл ажиллагаанд 223.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 11.5 сая

төгрөгийн бараа материалыг захирлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/49 тоот тушаалаар акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 50.7 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 0.1 сая төгрөгийн ном худалдан авч, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдсэн 10.0 сая төгрөгийн их засварыг, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 58.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1.4 сая төгрөгийн тавилга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс олгосон 1.4 сая төгрөгийн программ хангамжийг үнэгүй хүлээн авсан байна

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 831 дугаар тогтоол болон байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дугаар тушаалаар тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй 21.6 сая төгрөгийн машин, тоног, төхөөрөмжийг, 45.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг, 8.1 сая төгрөгийн ном буюу нийт 74.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 80.1 сая төгрөг болж өссөн нь халаалтын зардлын өглөг шинээр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 15.7 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,085.2 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр, зарлагын нийт дүнг 3,085.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж 1,107.8 сая төгрөгөөр бууруулж, 1,977.4 сая төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг 1,977.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,656.1 сая төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны төсвийн хэлбэлзлийн тайлангаар зарцуулах төсөв нь 2,915.8 сая төгрөг байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,656.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 259.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,550.1 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 259.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,809.7 сая төгрөг буюу 96.4 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 259,651.9 | 259,651.9 | - | 100.0 |
| 2 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,326,828.9 | 2,266,002.6 | 60,826.3 | 97.4 |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 210,488.8 | 192,331.0 | 18,157.8 | 91.4 |
| 4 | Дотуур байрны үйлчилгээ | 118,842.2 | 91,773.1 | 27,069.1 | 77.2 |
| | **Нийт дүн** | **2,915,811.8** | **2,809,758.6** | **106,053.2** | **96.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас түр сургалтын зардлын 17.0 сая төгрөгийн түр сургалтын мөнгө, жолооны сургалтаас 8.7 сая төгрөгийн, хөдөлмөр хамгааллын хувцас оёж нийлүүлсний 0.6 сая төгрөгийн, сургуулийн сурагчдын дадлагын хичээлээр хийсэн хогийн савыг худалдсаны 0.6 сая төгрөг, хүлэмжийн ангийн орлого 2.4 сая төгрөгийн, сургуулийн кабинет ашигласны түрээсийн төлбөр болох 1.1 сая төгрөгийн буюу нийт 30.3 сая төгрөгийн орлогыг нэмэлт дансанд оруулсан байна.

Үүнээс албан томилолтын зардалд 2.1 сая төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 22.9 сая төгрөгийн, нэг удаагийн тэтгэмж, урамшилд 5.3 сая төгрөгийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс зөвшөөрөл авч зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 358.5 сая төгрөгийн бараа материал, 0.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын  2,481.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 37.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 3,016.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 45.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар багш, ажилтнуудад шинэ жилийн бэлэг дурсгалын зүйлд 2.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 953.2 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 295.2 сая төгрөгийн 35 мөнгөн гүйлгээг төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 219.2 сая төгрөгийн 28 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>: Зөрчил арилгуулах* зөвлөмж өгөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цаг хугацааны хязгаарлалттай байдлаас болж 5 жил тутамд нэг удаа олгох тэтгэмжийн зарцуулалт, байгууллагын бүтэц орон тоо болон хичээл үйлдвэрлэл, дадлагын зардлаас олгосон хичээлийн болон дадлагын багаж хэрэгслийн олголт, зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар төсвийн зарцуулалтыг болон орон тоог дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд нийт 421,791.8 мянган төгрөгийн алдаа илэрч залруулга хийгдсэн. Үүнд:

1. Өмчийн өөрчлөлтийн тайланд актлагдсан 8,100.0 мянган төгрөгийн номыг Засгийн газрын оруулсан капитал данснаас бууруулж тайлагнасныг залруулав.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зарлагын дүнг 260,103.9 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 153,598.7 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 66,033.3 мянган төгрөгийн зөрчил илэрч 11,009.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 39,565.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 15,458.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр 11,009.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1. Сургуулийн захирлын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Б/34 дүгээр тушаалаар сургуулийн монгол хэл, уран зохиолын нэг багшид 5 жил тутамд нэг удаа олгох 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 9.0 сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна. Уг багш нь өмнөх 5 жилийн тэтгэмжийг 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 77 дугаар тушаалаар авснаас хойш 5 жил ажилласан байдлыг шалгаж үзэхэд 2015 оны сүүлийн 3 сар, 2016 онд 12 сар, 2017 онд 12 сар, 2018 онд 8 сар бүтэн, 1 сар хагас, ажиллаж 10,11,12 сар болон 2019 оны 1,2,3 дугаар саруудад сайн дурын нийгмийн даатгал төлсөн байна. Мөн оны 9,10,11 дүгээр сард ажиллаж 12 дугаар сараас 2020 оны 9 дүгээр сар хүртэл ажиллаагүй байна. 2021 онд 12 сар бүтэн, 2022 онд 7 сар, 2023 онд 1 сар ажиллаж 5 жил тутамд нэг удаа олгох 10 сарын тэтгэмжийг тухай байгууллагаас авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т ”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 19.3-т Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн ”Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно”, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-т “Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох”, Монгол Улсын дээд шүүхийн 2007 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Боловсролын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тогтоолын 11-т “Мөн зүйлийн 43.1.7-д заасан мөнгөн тэтгэмжийг тухайн сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт ажилласан эсэхээс үл хамааран сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт багшаар тасралтгүй 5 жил ажилласан нөхцөлд олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2.Сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар багш, ажилтнуудад шинэ жилийн бэлэг дурсгалын зүйлд 2.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас хууль бусаар олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т ”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

Аудитын дүнгээр 39,565.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

1.Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлын батлагдсан төсвөөс 26,215.0 мянган төгрөгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн зохих зөвшөөрөлгүйгээр төсвийн зардал хооронд зориулалт бусаар гүйлгэн зарцуулсан байна.

2.Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023 онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 13,350.5 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд оруулж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс зарцуулах зөвшөөрөл авч зарцуулан Нэмэлт төсвийн гүйцэтгэлээр тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “....төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсгийн 6.3.4-т “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 6.4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэгсийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 42 дугаар зүйлийн 42.4-т “энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 15.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

1.1 Илрүүлэлт:

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 953.2 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15.4 сая төгрөгийн 9 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлж, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 15.4 сая төгрөгийн 9 мөнгөн

гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 94.6 хувьтай байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах, өмч, хөрөнгө зарцуулсан тушаалыг шилэн дансанд байршуулах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг залруулсан | 1 | 413,702. | | | 1 | 413,702. | 1 | 413,702.6 | | | | |
| Өмчийн өөрчлөлтийн тайланг залруулсан | 1 | 8,089.2 | | | | 8,089.2 | | 8,089.2 | | | | |
| **Дүн** | 2 | 421,791.8 | | | 2 | 421,791.8 | 2 | 421,791.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 жил тутамд нэг удаа олгох 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг хууль бус олгосон | 1 | 8,959.4 | 1 | 8,959.4 | | | | | | | | |
| ХҮДЗ-аас зохих зөвшөөрөлгүйгээр төсвийн зардал хооронд гүйлгэн зарцуулсан. | 1 | 26,215.0 | | | 1 | 26,215.0 | | | | | | |
| Үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд оруулж зарцуулсан | | 13,350.5 | | | | 13,350.5 | | | | | | |
| Дүн | 2 | 48,524.9 | 1 | 8,959.4 | 1 | 39,565.5 | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байна. | 1 | 15,458.5 | | | | | 1 | 15,458.5 |
| **Дүн** | **1** | **15,458.5** | | | | | **1** | **15,458.5** |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсвөөс багш, ажилчдад гарын бэлэг өгсөн | 1 | 2,049.9 | 1 | 2,049.9 | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **17,508.4** | **1** | **2,049.9** | | | **1** | **15,458.5** |
| **Нийт дүн** | **4** | **66,033.3** | **2** | **11,009.3** | **1** | **39,565.5** | **1** | **15,458.5** |